



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1987 оны 2...
сарын 10... өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Уйлчилгээний зарим цэг салбар
1987 оны 161 р тогтоолоор нээж ажиллуулах тухай

Октябрийн районы ОСГ-ны 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хүн амын ахуйн үйлчилгээний цэг салбарын хүрэлцээ дутагдалтай байгааг харгалзан, тус тойргоос сонгогдсон АИХ-ын депутатын тавьсан хүсэлтийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:


1. Хүүхдийн хэсгийн эмнэлэг, эмийн сан, ахуйн үйлчилгээний цэг салбар нээхэд зориулан Бөөний худалдааны нэгдлийн 30 айлын орон сууцнаас 5 айлын сууцыг 1987 оны эхний хагас жилд багтаан чөлөөлж өгөхийг орлогч дарга н.Л.Энэбиш-д даалгасугай.

2. "Хоршоолол импекс" нэгдлийн ажилчдын халуун усны газрыг 1987 оны 2 дугаар сараас эхлэн долоо хоногт 3-аас доошгүй өдөр тус хорооны дэвсгэрийн хөдөлмөрчдөд үйлчилж байхыг хоршоолол импекс нэгдэл /н.Содном/, Халуун усны захиргаа /н.Сүхээ/-нд үүрэг болгосугай.

3. Хүнсний барааны 8 дугаар дэлгүүрийн 10371,0 төгрөгийн үнэтэй баглаа боодлын агуулахыг Аж үйлдвэрийн барааны нэгдэлд балансаас балансад шилжүүлж олгохыг Хүнсний барааны нэгдэл /н.Шагдар/-д зөвшөөрсүгэй.

4. Хүнсний барааны 8 дугаар дэлгүүрийн агуулахын барилгыг 1987 оны 3 дугаар сард багтаан засварлаж хөдөлмөрчдийн ергэн хэрэгцээний барааны мухлаг болгон нээж ажиллуулахыг Аж үйлдвэрийн барааны нэгдэл /н.Мижиддорж/-д даалгасугай.

5. Орон сууц гудамжны 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн зам талбайн 1234,4 мянган төгрөгийн тохижилтын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу 1988-1989 онд хийж гүйцэтгэхийг хот тохижуулах газар/н.Бадрах/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
 ЗАХИРГААНЫ ДАРГА *[Signature]* С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
 ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
 БИЧИГҮН ДАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ